



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 22/294

Улаанбаатар хот

Өрийн хэрэгсэл бүртгэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23 дугаар зүйлийн 23.11.5 дахь заалтууд, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/800 дугаартай албан бичгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компаниар дамжуулан арилжигдсан Нийслэлийн Засаг даргын гаргасан 3048 кодтой “Улаанбаатар бонд III” өрийн хэрэгслийн үндсэн төлбөр бүрэн төлөгдсөн тул “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.
2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдэгдлийг “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-д даалгасугай.
3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-д, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-д тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-т үүрэг болгосугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.ДӨЛГӨӨН

1525030607

Маягт 5

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №3048**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-д

Огноо: 2025/07/23

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас бүртгэлээс хасах тухай
Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/294 дугаартай тушаал, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/800 дугаартай албан бичиг
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Өрийн хэрэгсэл
Үнэт цаасны нэр:	Улаанбаатар бонд III
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	/3048, MUB/
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/	Энгийн
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	1,000,0
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100,000
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	100,000,000,000
Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь хэмжээ:	Жилийн 12%
Үнэт цаасны хугацаа:	12 сар
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	Хагас жил тутам

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДӨЛГӨӨН